

**“ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ТУХАЙ” ХУУЛЬ
(ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)-ИЙН ТӨСЛИЙН
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 35 дахь заалт, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2021 оны 02 дугаар зөвлөмжид “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тус тус тусгасны дагуу “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан, холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудаас саналыг авч нэгтгэн танилцуулж байна.

Улсын Их Хурлын 2002 оны чуулганы нэгдсэн хуралдаанаар “Цэрэг, цагдаагийн албан хаагчийг Нэгдсэн үндэстний байгууллагын энхийг сахиулах болон

олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай” анхдагч хуулийг баталж, 2010 онд “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай” нэртэйгээр хуулийн шинэчилсэн найруулга болгон өөрчилсөн. Хуулийн хэрэгжилтийг хангах хугацаанд 2014, 2016 онд өөрчлөлт, 2017 ондуудад нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

“Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Батлан хамгаалах болон Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүдийн хамтарсан тушаалаар байгуулсан “Ажлын хэсэг” боловсруулж, хуулийн төсөлд дараах зарчмын өөрчлөлтүүдийг тусгасан болно. Үүнд:

- Хуулийн зарим нэр томъёоны тодорхойлолтыг өөрчлөн найруулах;
- Энхийг дэмжих ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг нарийвчлан тодорхойлох;
- Монгол Улсын Их Хурал, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга болон Цагдаагийн төв байгууллагын даргын бүрэн эрх, Цэрэг, цагдаагийн багийн захирагчийн нийтлэг эрх, үүрэг, энхийг дэмжих ажиллагаанд оролцогч цэрэг, цагдаагийн алба хаагч, багийн нийтлэг үүргийг шинээр нэмэх;
- Засгийн газрын болон гадаад харилцаа, батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрхтэй холбогдох зохицуулалтыг нарийвчлан тодорхойлох;
- Энхийг дэмжих ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүнд хамаарах Нэгдсэн Үндэстний Байгууллагын албан тушаал, сонгон шалгаруулалтад тэнцсэн бие бүрэлдэхүүнийг томилох, эгүүлэн татах;
- Монгол Улсаас энхийг дэмжих ажиллагаанд цагдаагийн баг оролцуулах, үүрэг гүйцэтгэх төрөл;
- Энхийг дэмжих ажиллагаанд оролцогч хөдөлмөрийн чадвараа алдсан, нас барсан тохиолдолд НҮБ-аас нөхөн олговор олгуулах, ээлжийн амралтаа эдэлж

чадаагүй тохиолдолд мөнгөн урамшуулал олгох, үүрэг гүйцэтгэх хугацаанаасаа өмнө эгүүлэн татагдах тохиолдолд холбогдон гарах зардлыг тухайн алба хаагч өөрөө хариуцах, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг нарийвчлан тодорхойлох зэрэг болно.

“Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахад Монгол Улсын хувь нэмэр, үүрэг оролцоо нэмэгдэж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлийн шийдвэрээр энхийг сахиулах ажиллагаа болон олон улсын бусад ажиллагаанд оролцох хууль, эрх зүйн орчин боловсронгуй болж, энхийг сахиулагчдын аюулгүй байдал, эрх зүйн байдал, үүрэг гүйцэтгэх чадавх дээшилж, “АПСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан энхийг дэмжих ажиллагаанд оролцох оролцоо, чадавхыг нэмэгдүүлэх зорилтыг хангахад чухал нөлөө үзүүлж, хууль тогтоомжийн нийцэл, уялдаа холбоо хангагдах юм.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1, 3 дугаар зүйлийн 3.1, 38 дугаар зүйлийн 38.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс өмнө олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох материалыг баримтжуулан хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрт хавсаргана.”, мөн зүйлийн 38.5-д Олон нийтийн хэлэлцүүлгийг дараах хэлбэрээр явуулна: 38.5.3.санал асуулга явуулах, 38.5.4.олон нийтийн цахим сүлжээгээр хэлэлцүүлэг явуулах” гэж тус тус заасны дагуу төсөл болон холбогдох материалд олон нийтийн оролцоог хангах зорилгоор хуулийн төслийг холбогдох материалын хамт Батлан хамгаалах яамны цахим хуудас /mod.gov.mn/-т байршуулж, төрийн бус байгууллагаас саналыг авсан болно.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу боловсруулсан бөгөөд 2024 оны улсын төсөвт нэмэлт ачаалал үүсэхгүй болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

“ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ТУХАЙ” ХУУЛЬ (ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА)-ИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 35 дахь хэсэгт Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд “Монгол Улсаас НҮБ-ын болон олон улсын бусад ажиллагаанд оролцох төрлийг нэмэгдүүлж, энхийг дэмжих ажиллагааны удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, үүрэг гүйцэтгэх хугацаа, цэргийн багийг эргүүлэх татахтай холбогдсон эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тусгаж, хуульд “Цагдаагийн баг” гэсэн нэр томъёог шинээр тодорхойлж нэмэх, цагдаагийн алба хаагч, цагдаагийн багийг энхийг дэмжих ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүнд хамруулан тэдгээрийн гүйцэтгэх чиг үүргийг хуульчлан эрх зүйн орчныг баталгаажуулах”-тай холбогдох харилцааг зохицуулахаар “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг боловсруулахаар тусгасан.

Монгол Улсын Засгийн газар, Нэгдсэн үндэстний байгууллагын хооронд 1999 онд “НҮБ-ын байнгын хүчний тогтолцоонд хувь нэмэр оруулах талаар харилцан ойлголцсон тухай санамж бичиг”-ийг байгуулснаар нэгдсэн үндэстний байгууллагын энхийг сахиулах ажиллагаанд цэргийн хүчийг оролцуулах эрх зүйн орчин бүрдэж эхэлсэн.

Улсын Их Хурлын 2002 оны чуулганы нэгдсэн хуралдаанаар “Цэрэг, цагдаагийн албан хаагчийг Нэгдсэн үндэстний байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай” анхдагч хуулийг баталж, 2010 онд “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай” нэртэйгээр хуулийн шинэчилсэн найруулга болгон өөрчилсөн. Хуулийн хэрэгжилтийг хангах хугацаанд 2014, 2016 онд өөрчлөлт, 2017 онуудад нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Монгол Улсын Зэвсэгт хүчин нь анх 2002 онд Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс дахь НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд цэргийн ажиглагчаар хоёр офицерыг илгээснээс хойш өнгөрсөн 22 жилийн хугацаанд дэлхийн 4 тивд явагдсан НҮБ-ын 16 энхийг сахиулах, эвслийн цэргийн 4 буюу нийт 20 ажиллагаанд давхардсан тоогоор 22000 гаруй цэргийн алба хаагч, 2016 оноос 2023 он хүртэл цагдаагийн байгууллагаас нийт 30 гаруй алба хаагч оролцуулж, дэлхий нийтийн энх тайван, аюулгүй байдлыг тогтворжуулахад хувь нэмрээ оруулаад байна.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын энхийг сахиулах 6 ажиллагаанд штабын ажилтан, цэргийн мэргэжилтэн болон Мотобуудлагын батальоны цэргийн багт нийт 890 орчим цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгэж байгаа нь энхийг сахиулах ажиллагаанд цэрэг хандивлагч дэлхийн 121 улс орнуудаас 24 дүгээрт, эмэгтэй цэргийн алба хаагчдын оролцоогоор 17 дугаарт, Зүүн хойд Азийн улс орнуудаас 1 дүгээрт эрэмбэлэгдэж байна.

Энхийг сахиулах ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлэн 2023 оноос Бүгд Найрамдах Ливан Улсад явагдаж буй НҮБ-ын “UNIFIL” энхийг сахиулах ажиллагааны олон улсын цэргийн эмнэлгийн мэргэжилтнүүдээс бүрдсэн I+ шатны

эмнэлэгт цэргийн алба хаагчдыг үүрэг гүйцэтгүүлж эхэлсэн бөгөөд энхийг дэмжих ажиллагааны удирдах албан тушаалтны тоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Секторын штабын дарга, түүний орлогч, хэлтсийн даргын албан тушаалуудад алба хаагчдыг үүрэг гүйцэтгүүлж байгаа бол 2024 оноос Цэргийн хүчний командлагч, хэлтэс, албаны даргаар дахин 3 алба хаагч үүрэг гүйцэтгэхээр бэлтгэлээ хангаад байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2021 оны 02 дугаар зөвлөмжийн 2.1-д “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль, Цагдаагийн албаны тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;” гэж, Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан “АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 7.1-ын 4-т “Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг дэмжих ажиллагаа болон ... оролцох зэвсэгт хүчний оролцоо, чадавхыг нэмэгдүүлнэ.” гэж, “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.1.1.6-д “... олон улсын энхийг дэмжих үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно.” гэж, “Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал”-ын 13-т “НҮБ-ын болон олон улсын бусад энхийг дэмжих, сахиулах, сэргээн босгох үйл ажиллагаанд оролцох;” гэж, “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичгийн 8.3.3-т “зэвсэгт хүчний үндсэн чиг үүргээ биелүүлэх, энхийг дэмжих ажиллагаанд оролцох, ... чадавхыг нэмэгдүүлэх;” гэж, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 7.1.3-т “энхийг дэмжих ажиллагаа болон ... оролцох Зэвсэгт хүчний оролцоо, чадавхыг нэмэгдүүлнэ.” гэж, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.6.6-д “Батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, зэвсэгт хүчний олон улсын энхийг дэмжих ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлнэ.” гэж тус тус заасан нь тус хуулийн төслийг боловсруулах эрх зүйн үндэслэл болно.

Нөгөө талаар Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаа, хоёр талын хамтарсан хээрийн сургууль, дадлагад оролцох Монгол Улсын оролцооны цар хүрээ, оролцогчдын тоо жилээс жилд өсөн нэмэгдсэнтэй холбогдуулан энхийг дэмжих ажиллагаанд оролцох хууль, эрх зүйн орчныг илүү боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага бий болсон.

Иймд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд дэвшүүлсэн зорилтын дагуу энхийг дэмжих ажиллагааны хууль, эрх зүйн орчныг нийгмийн хөгжил, олон улсын харилцаа, хамтын ажиллагааны өөрчлөлтийг харгалзан “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах “Хамтарсан ажлын хэсэг”-ийг Батлан хамгаалахын болон Хууль зүйн сайдын хамтарсан тушаалаар байгуулан ажиллаа.

Ажлын хэсэг хуулийн төслийг боловсруулахад шатанд хуулийн 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль зүйн болон практик хэрэгцээ, шаардлага үүссэн тул Хууль тогтоомжийн тухай хуулийн 25.1.2-т заасныд дагуу “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

“Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг бүтцийн хувьд дараах агуулга бүхий 4 бүлэгтэй байхаар боловсруулсан болно. Үүнд:

1.Нэгдүгээр бүлэг: Нийтлэг үндэслэл буюу хуулийн зорилт, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль тогтоомж, хуулийн нэр томъёоны тодорхойлолт;

2.Хоёрдугаар бүлэг: Энхийг дэмжих ажиллагаанд оролцогч, түүний гүйцэтгэх үүрэг буюу Монгол Улсаас энхийг дэмжих ажиллагаанд Зэвсэгт хүчний цэргийн баг болон цагдаагийн багийн гүйцэтгэх үүрэг, Энхийг дэмжих ажиллагаанд оролцогч буюу цэрэг, цагдаагийн алба хаагч, багийн нийтлэг үүрэг;

3.Гуравдугаар бүлэг: Энхийг дэмжих ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, түүнд хамаарах Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, гадаад харилцаа, батлан хамгаалах, хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд болон Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Цагдаагийн төв байгууллагын даргын бүрэн эрх, мөн цэрэг, цагдаагийн багийн захирагчийн нийтлэг эрх, үүрэг

4.Дөрөвдүгээр бүлэг: Бусад зүйл буюу энхийг дэмжих ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүний эрх зүйн байдал, холбогдох зардал, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох.

Хуулийн төсөлд дараах зарчмын шинжтэй шинэ зохицуулалтыг тусгасан. Үүнд:

1. Монгол Улсын Их Хурал, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга болон Цагдаагийн төв байгууллагын даргын бүрэн эрх, Цэрэг, цагдаагийн багийн захирагчийн нийтлэг эрх, үүрэг, энхийг дэмжих ажиллагаанд оролцогч цэрэг, цагдаагийн алба хаагч, багийн нийтлэг үүрэг;

2. Монгол Улсаас энхийг дэмжих ажиллагаанд цагдаагийн баг оролцуулах, 8 төрлийн гүйцэтгэх үүрэг;

3. Энхийг дэмжих ажиллагаанд оролцогч хөдөлмөрийн чадвараа алдсан, нас барсан тохиолдолд НҮБ-аас нөхөн олговор олгуулах;

4. Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн цэрэг, цагдаагийн алба хаагч ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй тохиолдолд холбогдох хуульд заасан мөнгөн урамшуулал олгох;

5. Цэргийн алба хаагч Нэгдсэн Үндэстний Байгууллагаас зарласан энгийн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцэж, үүрэг гүйцэтгэх тохиолдолд албанаас чөлөөлөх;

6. Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч Монгол Улсын болон тухайн улсын хууль тогтоомж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм, журам, олон улсын гэрээг зөрчсөн, сахилгын ноцтой зөрчил гаргасан, гэмт хэрэгт холбогдон хугацаанаас өмнө эгүүлэн татагдах тохиолдолд түүнтэй холбогдон гарах зардлыг тухайн алба хаагч өөрөө хариуцах;

7. Энхийг дэмжих ажиллагаанд цагдаагийн баг оролцуулсантай холбогдох нөхөн төлбөр, олгох томилолтын зардал болон Цагдаагийн хөгжлийн санд төвлөрүүлэх хувь хэмжээг тогтоох зэрэг болно.

“Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдуулан боловсруулсан хуулийн төслийн агуулгын талаар:

1.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд Цагдаагийн хөгжлийн санг тусгай хуулиар зохицуулах эрх зүйн зохицуулалтыг;

2.Цэргийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд цэрэг, цагдаагийн алба хаагч Нэгдсэн Үндэстний Байгууллагаас зарласан энгийн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцэж, үүрэг гүйцэтгэх тохиолдолд албанаас чөлөөлөх, энгийн албан тушаалд үүрэг гүйцэтгэхтэй холбогдуулан цэргийн албанаас чөлөөлөгдсөн тохиолдолд таван жилийн дотоор эгүүлэн томилж болохтой холбогдсон эрх зүйн зохицуулалтыг;

3.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд цэрэг, цагдаагийн алба хаагч Нэгдсэн Үндэстний Байгууллагаас зарласан энгийн албан тушаалын үүрэг гүйцэтгэсэн хугацааг цэргийн алба хаасан хугацаанд оруулан тооцохгүй байхтай холбогдох эрх зүйн зохицуулалтыг;

4.Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд Цагдаагийн хөгжлийн сангийн эх үүсвэр, зарцуулалттай холбогдох эрх зүйн зохицуулалт болон цагдаагийн алба хаагчийн энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн хугацааг нэмэгдүүлэн тооцохтой холбогдох эрх зүйн зохицуулалтыг;

5.Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөлд “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай” хууль (шинэчилсэн найруулга) батлагдсантай холбогдуулан тус хуулийг хүчингүй болсонд тооцохтой холбогдох эрх зүйн зохицуулалтыг тус тус тусгасан болно.

“Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-т заасны дагуу Цэргийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай зэрэг хуулийн төслүүдийг хамтад нь боловсруулсан болно.

Хуулийн төсөл батлагдсанаар дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахад Монгол Улсаас оруулж буй хувь нэмэр, үүрэг оролцоо нэмэгдэх, энхийг дэмжих ажиллагаанд оролцох хууль, эрх зүйн орчин илүү боловсронгуй болох, энхийг сахиулагчдын эрх зүйн байдал, үүрэг гүйцэтгэх чадвар сайжрах, Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан энхийг дэмжих ажиллагаанд оролцох оролцоо, чадавхыг нэмэгдүүлэх зорилт хангагдах зэрэг чухал ач холбогдолтой юм.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1, 3 дугаар зүйлийн 3.1, 38 дугаар зүйлийн 38.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс өмнө олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох материалыг баримтжуулан хууль

тогтоомжийн төслийн бүрдүүлбэрт хавсаргана.”, мөн зүйлийн 38.5-д Олон нийтийн хэлэлцүүлгийг дараах хэлбэрээр явуулна: 38.5.3.санал асуулга явуулах, 38.5.4.олон нийтийн цахим сүлжээгээр хэлэлцүүлэг явуулах” гэж тус тус заасны дагуу төсөл болон холбогдох материалд олон нийтийн оролцоог хангах зорилгоор хуулийн төслийг холбогдох материалын хамт Батлан хамгаалах яамны цахим хуудас /mod.gov.mn/-т байршуулж, төрийн бус байгууллагаас саналыг авсан болно.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу боловсруулсан бөгөөд 2024 оны улсын төсөвт нэмэлт ачаалал үүсэхгүй болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР